

Үйл ажиллагааны тайлан
2016

ХӨХ ГАН ХК АНГИЖРУУЛСАН ТӨМРИЙН ҮЙЛДВЭР



WWW.KHUKHGAN.MN

ХӨХ ГАН ХК




БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛТ





БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





ХӨХ ГАН ХК ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Хөх ган ХК нь Монголын анхны шууд ангижруулсан төмөр боловсруулах үйлдвэрийн нэг юм.

2007 онд Монгол улсын Бэрэн групп ХХК болон Сингапур улсын Фабер Инвестмент хөрөнгө оруулалтын компанийн хамтарсан хөрөнгө оруулалтаар анх байгуулагдсан.

2008 онд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гарган өнөөдрийн хэмжээнд 900 гаруй хувьцаа эзэмшигчидтэй. Тус үйлдвэрийг барьж байгуулах явцад хөрөнгө оруулагч хоёр талаас нийт 7.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд үйлдвэрийн дараагийн шугамыг барьж дуусгахад нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай болсны улмаас 2008 оны 08 сард “Хөх ган” ХХК-ийг Хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, хөрөнгийн зах зээлд хувьцаа гарган борлуулах замаар 3.0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтыг нэмж татан төвлөрүүлсэн.

2009 онд Үйлдвэрийн эхний шугамыг ашиглалтанд оруулж, Монгол улсад анхны Ангижруулсан төмрийг үйлдвэрлэсэн юм. Тус онд Дарханы хар төмөрлөгийн үйлдвэртэй гэрээ байгуулан шууд ангижруулсан төмөр нийлүүлж эхэлсэн. Энэхүү ангижруулсан төмрийг хайлуулан арматур, ган бэлдэц гаргаснаар Монгол улс өөрийн орны төмрийн хүдрээс шат дараалан боловсруулж эцсийн бүтээгдэхүүн анх удаа гаргасан.

2010 онд Монгол улс Засгийн газар, МҮХАҮТ-аас хамтран зохион байгуулсан “Монголд үйлдвэрлэв- 2009” үзэсгэлэнд Шууд ангижруулсан төмөр бүтээгдэхүүнээрээ оролцож, үзэсгэлэнгийн Гран-при шагналыг авсан юм.

Манай компанийн үйлдвэрлэдэг шууд ангижруулсан төмөр нь хаягдал төмөр, ширмийг бүрэн орлох ба чанар, үр ашгийн хувьд илүү, сайн чанарын ган үйлдвэрлэхэд үндсэн түүхий эдээр хэрэглэдэг. Тус үйлдвэр нь жилдээ 40 мян.тонн төмрийн хүдрийн баяжмал боловсруулж, 30 мян.тонн 84-92% төмрийн агуулгатай ШУУД АНГИЖРУУЛСАН ТӨМӨР үйлдвэрлэх хүчин чадалтай Монгол улсын хувьд анхны төмрийн баяжмалыг боловсруулж буй металл төмөр үйлдвэрлэгч үйлдвэр юм. Тус компани нь БНХАУ-н металлургийн тэргүүлэх компаниудтай хамтран ажилладаг бөгөөд өөрийн улсаас авах боломжгүй түүхий эд материалыг дээрх компаниудаас импортлон авдаг юм.



Үүсгэн байгуулагдсанаас хойш өнөөдрийг хүртэл 250 гаруй ажилчин, албан хаагчидтай болж өнөр өтгөн хамт олон болж үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Үйлдвэрийн дэргэд ган төмөрлөг үйлдвэрлэх ган, ширмийн үйлдвэрүүд баригдаж байгаа нь эдгээр үйлдвэрийг түүхий эдээр хангах эрхэм зорилготой юм.

2011-2012 онд ОХУ-д болон БНХАУ-д анхны бүтээгдэхүүнээ импортолж, хэрэглэгчийн хүрээгээ тэлсэн.

2013-2015 онд шинээр гангийн үйлдвэрт хэрэглэгдэх түүхий эд бүтээгдэхүүн болох кокс болон агломерат үйлдвэрлэсэн.


2016 онд Дэлхийн зах зээлд төмрийн үнэ эрс унасан, үүнээс шалтгаалан төмрийн хүдрийн экспорт буурсан, улс орны эдийн засгийн хүндрэл, валютын ханшны өсөлт болон тус үйлдвэрийн үндсэн түүхий эдийг бэлтгэгч Архангай аймаг дахь төмрийн хүдрийн уурхай, баяжмалын үйлдвэр удаан хугацаагаар зогссон зэрэг шалтгааны улмаас 2015 оны хагас жилээс 2016 он дуустал сул зогсолт хийгээд байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

"Хөх ган"ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц
/2016.04.08 бүртгэлийн өдрөөр/




Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллагаа нь ТУЗ байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.


ТУЗ нь 9 гишүүнтэй, 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 1 жил. ТУЗ-ийн гишүүн компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино. ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн зөвшөөрснөөр тодорхой асуудлаар тушаал, шийдвэр гаргах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

“Хөх ган”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4 сарын 29-ний өдөр хуралдан дараах гишүүдийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгов.

2016 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар “Бэрэн групп”ХХК-ын ерөнхий захирал Б.Мөнхтөр, гүйцэтгэх захиралаар Ц.Батболд нар ажиллав. Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон гүйцэтгэх удирдлагын бүтэцэд өөрчлөлт ороогүй болно.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл бүрэлдэхүүн:





Хөх ган ХК-ийн ТУЗ-ийн хурлыг жил бүр зохион байгуулдаг ба нийт гишүүдийн биечилсэн хурлыг жилд 1 удаа явуулдаг. ТУЗ нь Аудит, Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал гэсэн гурван байнгын хороотой.


Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4 сарын 28-ны өдрийн 13:30 минутаас “БиДиСЕК” ХК-ийн хурлын зааланд болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг энэхүү үйл ажиллагааны тайлангийн сүүл хэсгээс харна уу.

2017 оны 4 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр нь 2017 оны 4 сарын 7-ны өдөр бөгөөд тус өдрөөр тасалбар болон хувьцаа эзэмшигчдийн тархалтын судалагаа буюу хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг авч хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт орсон талаар мэдээллийн МХБ-ийн сайтанд мэдээлэх болно.





ХӨХ ГАН ХК – ИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАГВАР



Манай компаний томоохон зорилт болох уул уурхай, металлургийн салбарт монголдоо тэргүүлэх технологитой компани болон хөгжих, импортын бүтээгдэхүүнийг орлох, монголын гангийн эрэлт хэрэгцээг 100% хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана.



БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Уул уурхайн салбар нь Монгол улсад үүсч хөгжөөд олон жил болж байгаа боловч 2000 он хүртэл төмрийн хүдрийн олборлолт ,баяжуулалтын технологи нэвтрээд удаагүй залуу салбар байлаа.

Тус компаний групп толгой компани болох Бэрэн групп ХХК нь 2003 оноос төмрийн хүдрийн олборлолт ,хар металлурги , ган төмрийн чиглэлээр эрэл хайгуул, судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлж, энэ салбарт хөрөнгө оруулалт хийж эхэлсэн.Ингэснээр 2007 онд Монгол улсад анх удаа төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр, уурхайг барьж, ашиглалтанд оруулж чадсан билээ.

Улмаар олон улсад сүүлийн үед ашиглаж эхэлсэн шинэ технологи болох төмрийн баяжмалыг шууд ангижруулах технологиор боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулсан нь Хөх ган ХК юм. Тус үйлдвэр нь энэ чиглэлийн Монгол улсын ууган үйлдвэр гэдгээрээ онцлог юм. Металлургийн салбарт цаашид хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, дээрх үйлдвэрүүдийнхээ хүчин чадлыг өргөтгөж, шинэ төслүүлийг хэрэгжүүлж, эцсийн бүтээгдэхүүн буюу ган төмөр үйлдвэрлэх эрхэм зорилт тавин ажиллаж байна.

Орчин үеийн технологиор төмрийн баяжмалыг боловсруулж, сайн чанарын ган үйлдвэрлэх шаарлагад тохирох бүтээгдэхүүн гаргах ба ингэснээр эхний ээлжинд уг бүтээгдэхүүнээ экспортлох, цаашдаа Монгол улсад төмөрлөгийн болон гангийн үйлдвэрлэлийг гадны хамгийн сүүлийн үеийн шинэ технологи нэвтрүүлэх замаар дэлхийн хөгжлийн чиг хандлагыг амдан хөгжүүлэхэд чиглэн ажиллаж дотоодын үйлдвэрлэлийн салбарын төмөр болон ган бүтээгдэхүүний эрэлтийг ханган ажиллаж байна.



ЦЕХ, ХЭСЭГ

ЭХНИЙ ДАМЖЛАГЫН ПРОЦЕСС



ЦЕХ, ХЭСЭГ

ХОЁРДОГЧ ДАМЖЛАГЫН ПРОЦЕСС



ЦЕХ, ХЭСЭГЭ

ЦСИЙН ДАМЖЛАГЫН ПРОЦЕСС



(Түүхий эд материал бэлтгэх хэсэг)

Энэ хэсэгт шохой, нүүрсний нунтаглалт, шигшилтийн түүхий эд материал бэлтгэх хэсэг хамаарна.

(Нүүрс хийжүүлэх хэсэг)

Энэ хэсэгт нүүрс хийжүүлэх зууханд ачаалах нүүрсний бутлалт, нунтаглалт, шигшилтийн процесс хамаарна.

(Хэвлэх хэсэг)

Энэ хэсэгт хонгилон зууханд ачаалах баяжмал, нүүрсийг шахах, хэлбэржүүлэх процесс хамаарна.

(Нүүрс хийжүүлэх хэсэг)

Эхний дамжлагын процессоос бэлтгэсэн тодорхой диаметр ширхэгтэй материалыг нүүрс хийжүүлэх зууханд буюу 1 шатлалт процессоор ачаалан шаардлагатай сингаз хий үүсгэх хэсэг хамаарна.

(Хонгилон зууханд ачаалах хэсэг)

Эхний дамжлагын бэлтгэх хэсгээс ирсэн ТЭМ-ыг ачаалах тэргэнцэрт өрөлтийн зарчмаар өрж зууханд ачаална.

(Нүүрс хийжүүлэх хэсэг)

Нүүрс хийжүүлэх зуухнаас ачаалсан сингаз хийг ангижруулах зуухаар нэвтрүүлэн зуухыг халаан, нэмэлт хүчилтөрөгч үлээлгэн ангижруулах нөхцлийг бий болгоно.

(Хонгилон зууханд ачаалах хэсэг)

ТЭМ-тай тэргэнцэрийг 45 минутаас 60 минутын хугацаанд хонгилон зууханд ачаалан ангижруулалтыг 1150°C -т байлган 48-72 цагийн дараа эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.



Бүтээгдэхүүн

Шууд ангижруулсан төмөр

Манай үйлдвэрийн үйлдвэрлэх шууд ангижруулсан төмөр нь хаягдал төмөр ширмийг бүрэн орлох ба чанар, үр ашигийн хувьд илүү, сайн чанарын ган үйлдвэрлэхэд үндсэн түүхий эдээр хэрглэгддэг.

Шууд ангижруулсан төмөр Fe - (84 – 87%).

Агломерат

Бид бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн цар хүрээг өргөжүүлэх зорилгоор, ширмийн үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд агломератыг боловсруулан үйлдвэрлэж гаргасан.

Домен зуухны кокс

Домен зуухны үйл ажиллагаанд чухал үүрэгтэй ангижруулагч түүхий эд материал нь кокс юм. Коксын хэрэглээ нь ган төмөрлөгийн зах зээлд эрэлт ихтэй, импортыг орлох бүтээгдэхүүний туршилтыг хийж эхлээд удаагүй ч амжилттай үйлдвэрлэлийн туршилтыг хийж, хэрэглэгчдэд нийлүүлсэн.

Бид бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах зорилгоор өөрсдийн судалгаа, шинжилгээ туршилтыг хийж байгаа бөгөөд хамтран ажиллагч байгууллагууд, зөвлөх инженерүүдтэй гүйцэтгэж байна.

Уул уурхай, металлургийн салбар нь улс орны томоохон чухал салбар учир үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэрэглээ, эрэлт тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа юм.



КОМПАНИЙ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Ажиллагсад нь компанийн үнэт зүйл учраас, Хөх ган ХК нь шийдвэр гаргах бүхий л түвшинд тэдгээрийн оролцоог хангаж, олон улсын дэвшилтэт туршлагыг мөрдлөг болгодог. Тухайлбал, ажиллагсаддаа жил бүр үйл ажиллагааныхаа талаар тайлагнаж, ажиллагсдын хэлэлцүүлгийг улирал бүр зохион байгуулдаг бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад төрлийн нээлттэй уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулдаг.



Хөх ган компанийн хувьд Компанийн нийгмийн хариуцлага гэх ойлголтыг дан ганц хандив, тусламж, богино хугацааны төсөл, хөтөлбөрүүдийн хязгаарлагдмал хүрээнд авч үздэггүй бөгөөд олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах замаар ирээдүйн тогтвортой хөгжлийн бат бэх суурийг бий болгохоор зорьж ажилладаг.

Ган төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийн бүтээн байгуулалт, ажлын далайцаас шалтгаалан ажиллагсдын тоо хурдацтай өсөн нэмэгдэж орон нутгийн иргэд бүрдүүлдэг төдийгүй Орхон аймгийн Говил багийн иргэдийн тогтвортой ажлын байр бий болж, энэ утгаараа компанийн зүгээс тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хувь хүний болон мэргэжлийн хувьд тасралтгүй өсөн дэвжих боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллаж байна.

Хөх ган ХК –иас зохион байгуулдаг төсөл хөтөлбөрийн цар хүрээ нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн.

Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр
Боловсролыг дэмжих хөтөлбөр
Байгаль орчны хамгаалал хөтөлбөр



Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр

Үйлдвэрийн ажилчидын эрүүл мэндийг сайжруулах замаар эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах зорилготойгоор Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээ төвтэй хамтран зохион байгуулж ирлээ.

Энэ өдөрлөг хөтөлбөр нь тодорхой өвчнөөс урьдчилан сэргийлэх нарийн үзлэг оношлогоо, халдварт бус өвчлөлүүд болох хавдар, чихрийн шижин, цусны даралт, зүрх судасны болон нөхөн үржихүйн өвчлөлүүдийн талаар ажилчидад мэдээлэл, эмчилгээ өгөх, тэднийг сургах, үзлэг зөвлөгөө өгөх зорилготой.

Түүнчлэн УБ хотын төв клиникийн эмч мэргэжилтнүүд үйлдвэрийн эмч нарт сургалт явуулах туршлага солилцдог бөгөөд ажилчидад эрүүл мэндийн үзлэгийг хийж ирсэн.

Боловсролыг дэмжих хөтөлбөр

Ажилчны ирээдүй Сурлагатай сурагч хөтөлбөр

2008 оноос хэрэгжиж буй энэхүү хөтөлбөрийн хүрээнд манлайлагч ажилчны сурлагатай сурагчийг (бүрэн бус, бүрэн дунд) боловсролын төгсөлтөнд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Мөн цаашид суралцах хугацаанд дадлагажих болон ажиллах боломж олгох замаар компанийн хүний нөөцийг бэхжүүлэх, улмаар Орхон аймгийн хөгжилд оюуны хөрөнгө оруулалт хийдэг ач холбогдол оршиж байна.

Хөх ган ХК болон ШУТИС Хамтын ажиллагаа оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Хөх ган ХК ба ШУТИС дотоодын чадварлаг инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх чиглэлд хамтран ажиллах тухай гэрээг 2009 онд байгуулсан. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд тус сургуулийн оюутнуудад зориулсан дадлагажих цалинтай тэтгэлэгт нөхцлийг бүрдүүлж амжилттай хэрэгжүүлж байна.

Хөх ган ХК болон Орхон аймгийн ХАА МСҮТ-ийн ажиллах хүчин бэлтгэх хөтөлбөр

Тоног төхөөрөмж, зуухны оператор, засварчин, гагнуурчин зэрэг ажилтнуудыг бэлтгэх чиглэлд хамтран дадлагажих, сургалтын хөтөлбөрт технологийн багш нарт мэргэжлийн болон арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлж хамтран ажиллаж байна.

Тус мэргэжлээрээ амжилттай төгссөн оюутнуудыг ажлын байраар хангах боломжийг бүрдүүлдэг.

Байгаль орчны хамгаалал хөтөлбөр

Жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг байгаль орчин, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн ойр орчим, Говил багийн нийтийн эзэмшлийн зам дагуу, 4,5 саруудад мод тарьж ногоон орчинг бүрдүүлэх үйлсэд ажилчдын оролцоотойгоор манлайлан оролцож тус тус тарьялаа.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Өндөр үр бүтээлтэй ажиллахын тулд аливаа байгууллага хүний нөөцийн оновчтой уян хатан бодлого явуулах нь чухал. Тийм учраас аливаа байгууллагын хамгийн чухал нөөц бол хүн гэдэг нь зайлшгүй юм.

Хүний Нөөцийн бодлого, зорилт нь шударга, эрх тэгш, эерэг таатай орчинг бий болгож компанийн эрхэм зорилго, алсын хараа стратеги төлөвлөгөөнд тулгуурлан компанийн хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, судалж сонгох, ажилд томилох, сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах, ахлах болон мэргэжлийн ажилтнуудын тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор тэдгээрийн албан тушаалыг залгамжлах хүмүүсийг тодорхойлох, албан тушаалд сэлгэж ажиллуулах зэрэг хүний нөөцтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Манай компанийн хүний нөөцийн менежментийн гол зорилго нь ажилтан бүрийн авъяас чадвар, нөөц боломжуудыг нээн илрүүлж хөгжүүлэх, хүмүүсийг санаачлагатай ажиллахад уриалан дуудах, байгууллагын өмнө тавигдсан зорилгыг биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх орчин нөхцлийг бүрдүүлэх, чадварлаг мэргэшсэн хүмүүсийг өөртөө татах, тэднийг тогтоон барих, ажилтан бүрийн хувийн чадварыг бүрэн нээж, оновчтой ашиглахад чиглэнэ.

Үйлдвэрийн эрхэм зорилгод нийцүүлэн хүндээ чиглэсэн үйл ажиллагааг хүний нөөцийн менежментийн арга зүйг ашиглан явуулснаар өрсөлдөх чадвар бүхий боловсон хүчнийг бүрдүүлж төлөвшүүлэх стратегийг баримтална.

Дээрх стратегид хүрэхийн тулд хүний нөөцийн бодлогын дараах үндсэн чиглэлүүд хэрэгжинэ.


- Хүний нөөцийн баг: Ажилтан-байгууллага хоорондын холбох, харьцах гүүр болж ажиллана.
- Хамгийн үр дүнтэй хөрөнгө оруулалт бол ажилтнаа байнгын сургалтанд хамруулахад оршино. Сургалтын хуваарийн дагуу ажилтнаа хэрэгтэй, шаардлагатай сургалтанд хамруулж, үр дүнтэй, бүтээмжтэй ажиллах ур чадварыг эзэмшүүлнэ.
- Манай компанид бүх насны хүмүүс ажилладаг бөгөөд бид нас, хүйс, үндэс угсаа, нийгмийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй.
- Байгууллагын дотоод журам, хамтын гэрээг нийт ажилтнууддаа нээлттэй танилцуулж, хөдөлмөрийн харилцааны холбогдох хуулиудыг чанд баримталж



ажиллана.

- Ажилтан-удирдлагын баг хоорондын зөв харилцаа, харилцан бие биенээ ойлголцох нь бас нэгэн чухал асуудлын нэг.
- Аль болох дотоод эх үүсвэрээс дэвшүүлэн ажиллуулах, бага зардлаар хамгийн үр дүнтэй замаар ажилтан сонгон шалгаруулж шилдэг боловсон хүчнийг бэлдэнэ
- Аюулгүй, таатай, бүтээмж хамгийн өндөр байх дамжлагын зохицуулалтай ажлын байраар ажилтнаа хангаж, нийт ажилчдын дунд найрсаг уур амьсгал бүрдүүлэхэд анхаарал тавин ажиллана.


ХҮНИЙ НӨӨЦ



Манай компаний амжилтын эх үндэс болсон харилцагчийн итгэл найдварыг хүлээсэн ажилтнуудаа чадавхжуулах, хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшуулал олгож, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар урт хугацаанд тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажилладаг.



Ажилчдын тоо





ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Байгууллагын стратеги төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг байх шаардлагатай бөгөөд өдөр тутмын үйлдвэрлэлтийн нөхцөлд болзошгүй алдагдлыг боломжит түвшинд бууруулах эрсдлийн удирдлагын үр ашигтай системийг бий болгож, хэрэгжүүлэхэд чиглэгддэг бөгөөд дараахь үе шатын дагуу стандартуудыг мөрдөж ажилладаг.

Хөх ган ХК нь шинжилгээ стресс тест болон сценарийн шинжилгээ хийх, эдийн засгийн салбар болон хөрөнгө оруулагчийн төлбөрийн лимит тогтоох, анхаарал татсан их хэмжээний мөнгөн урсгалыг хянах замаар удирдан ажилладаг. 2015 онд үйлдвэрлэлтийн өртөг хянах боломжит байдлаас 10%-р бууруулаж, ашиг орлогыг нэмэгдүүлж, эрсдэлийг тогтоох, дүн шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийг бууруулах, хяналт шинжилгээ болон дүгнэлт нэмэлт модулийг нэвтрүүлэв.

Мэдээлэл солилцох болон харилцан зөвлөлдөх:

Санхүүгийн эрсдэл

Паркийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны бүхий л үе шатуудад байгууллагын бүх шатны удирдлагуудын хүрээнд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох, харилцан зөвлөлдөх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, эрсдэлийн удирдлагын шат шатанд нь асуудлыг, бүх шатны удирдлагуудыг оролцуулан, олон талаас нь авч хэлэлцүүлэг хийж идэвхтэй манлайлан оролцож байна.

Байгууллагын хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаа болон өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болзоггүй хууль тогтоомж, зах зээл, валютын ханш болон хүүгийн өөрчлөлт зэрэг гадаад орчны нөлөөллөөс гадна валютын хөрвөх чадвар болон мөнгөний урсгал зэрэг дотоод хүчин зүйлүүдээс үүсэх магадлалтай эрсдэлүүдийг урьдчилан сэргийлж арга хэмжээ авч ажиллаж байна.

Энэ нь байгууллагын буруу үйл ажиллагаа, албан хаагчид болон системийн зүгээс



Үйл ажиллагааны эрсдэл

учирч болзошгүй эрсдэлүүдийг хэлэх бөгөөд дүрэм, журмын өөрчлөлт, байгууллагын соёл, удирдлагын өөрчлөлт зэрэг гадаад орчны нөлөөллөөс гадна байгууллагын албан хаагчдын алдаатай үйл ажиллагаа зэрэг дотоод хүчин зүйлүүдээс үүсэх магадлалтайг анхаарах нь зүйтэй.

Болзошгүй хүчин зүйлийн эрсдэл

Байгаль, цаг уурын гэнэтийн өөрчлөлт зэрэг гадны нөлөөллөөс үүсэхээс гадна байгууллагын албан хаагчдын гэмтэл, осол, эд хөрөнгийн хохирол зэрэг дотоод хүчин зүйлсээс үүсэх магадлалтай юм.

Компанийн паркийн үйл ажиллагаанд учрах санхүүгийн эрсдлийг ерөнхийд нь гурван хэсэгт ангиллаа.

- **Инфляцийн эрсдэл.** Инфляци өндөр буюу юмны үнэ өсч байгаа үед хөрөнгө оруулалтын өгөөж, ашгийн хувь хэмжээ инфляцийн түвшингээс доогуур байх, Инфляци өсөж буй үед үйлдвэрүүд сул чөлөөтэй байгаа мөнгийг хүүтэйгээр банкинд байршуулбал мөнгөний худалдан авах чадварын бууралтыг тодорхой хувиар бууруулах бодлого хэрэгжүүлсэн.
- **Бизнесийн эрсдэл.** Ашигтай ажиллаж чадаагүй компани ногдол ашиг тарааж чадахгүй бөгөөд ногдол ашиг өгдөггүй компани хувьцааны үнэ буурна. Иймээс бид бүхэн ашигтай ажиллаж энэ бүх эрсдэлээс урьдчилан сэргийлж эрсдэлийг өрсөж харах нь чухал юм.
- **Зах зээлийн эрсдэл.** Хөрөнгө оруулагчдын шийдвэр, зан төлвөөс хамааран хувьцаа, бонд, бусад хөрөнгө оруулалтын үнэ байнга өөрчлөгдөж байдаг билээ. Эдийн засгийн өсөлт, бууралтыг урьдчилан таамаглахад бэрх байдаг. Ерөнхийдөө эдийн засгийн өсөлт өндөртэй он жилүүдийн дараа эдийн засгийн бууралт, уналт дагалдаж байдаг. Мөн зах зээлийн үнэ ханш нийгэм, улс төр, олон улсын нөхцөл байдлаас ч ихээхэн хамааралтай байна.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2013-2016 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Дэлхийн зах зээлд төмрийн үнэ эрс унасан, үүнээс шалтгаалан төмрийн хүдрийн экспорт буурсан, улс орны эдийн засгийн хүндрэл, валютын ханшны өсөлт болон тус үйлдвэрийн үндсэн түүхий эдийг бэлтгэгч Архангай аймаг дахь төмрийн хүдрийн уурхай, баяжмалын үйлдвэр удаан хугацаагаар зогссон зэрэг шалтгааны улмаас 2015 оны хагас жилээс 2016 он дуустал сул зогсолт хийгээд байна.

Хөх ган ХК нь өнгөрсөн онуудад бүтээгдэхүүн туршилтуудыг амжилттай хийсэн бөгөөд энэ ондоо үйлдвэрлэх боломжит бүх бүтээгдэхүүнээ туршилагатай үйлдвэрлэн гаргах бүрэн боломжтой. Иймд 2017 ондоо бид DRI үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа.

Өнгөрсөн онуудын санхүүгийн үзүүлэлтүүд.

ХӨРӨНГӨ

2016 оны байдлаар нийт хөрөнгийн хэмжээ эргэлтын хөрөнгө 5,504.2 сая/төг буюу 18% ,Үндсэн хөрөнгө 25,596.3 сая/төг буюу 82% ,хувьцааны хөрөнгө оруулалт 10,131.7 сая/төг буюу 33%-тай байна.




БОРЛУУЛАЛТ

2013 онд шинээр Агломератын туршилтын бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн.

2014 онд агломерат нийт үйлдвэрлэл 6140,9 тн. Борлуулалт 6634 тн.

2015 онд гангийн түүхий эд болох коксын туршилтыг хийж бүтээгдэхүүн төрлийг нэмэгдүүлж 918.7 тн кокс үйлдвэрлэсэн. Цэвэр борлуулалт 521.4 сая.төгрөг хийсэн.

2016 онд санхүүгийн хямрал хүндэрлийн улмаас сул зогсолт хийгээд байна.





ӨӨРИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Компани нь 2015 онд дахин үнэлгээ хийгдэж нийт хөрөнгө өмнөх оноос 42%-иар буюу 15.9 тэрбум.төгрөгөөр өсч 27.6 тэрбум.төгрөг ба үүнээс 15 %-ийг эргэлтийн ,85%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна .

2016 онд үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтэглээр 7.4%-р буурсан үзүүлэлтэй байна.



/сая.төгрөгөөр/

“Хөх ган”ХК нь 2016 онд их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна.

“Хөх ган”ХК нь 2016 онд сул зогсолт хийж үйл ажиллагаа явуулаагүй учир компани алдагдалтай ажилласан. Иймд энэ жил ногдол ашиг хувиарлахгүй байхаар ТУЗ-ээс шийдвэрлэсэн. Компаний үйл ажиллагааг жигд явуулж ашигтай ажиллабал компанийн дүрэм болон ногдол ашгийн журмын дагуу ногдол ашиг хуваарлан ажиллана.



ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА
“Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК

2017. он 03 сар 15 өдөр

№ 87/АТ

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Хөх Ган” ХК-ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

“Хөх Ган” ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Хөх Ган” ХК - ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлага энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлсон.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 4-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Хөх Ган” ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

- 6 -



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

(мянган төгрөгөөр)

	Лавлагаа	2015	2016
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	3	16,339.7	16,260.2
Дансны авлага	4	3,008,994.2	2,997,346.3
Татвар НДШ-ийн авлага	4	77,152.0	83,503.9
Бусад авлага	4	1,000.0	1,000.0
Бараа материал	5	915,221.5	2,397,645.3
Урьдчилж төлсөн зардал / тооцоо /	6	8,502.5	8,502.5
Эргэлтийн хөрөнгийн дүн		4,027,209.9	5,504,258.2
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө, цэвэр	7	27,643,854.8	25,595,280.7
Биет бус хөрөнгө	8	1,000.0	1,000.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		27,644,854.8	25,596,280.7
Нийт хөрөнгийн дүн		31,672,064.7	31,100,538.9
Өр төлбөр			
Дансны өглөг	9	12,709,416.1	13,663,861.8
Цалингийн өглөг	9	168,465.3	161,699.4
Татварын өглөг	9	58,462.3	90,911.4
ЭМНДШ-ийн өглөг	9	118,942.8	114,168.1
Бусад богино хугацаат өглөг	9	1,337.2	1,337.2
Урт хугацаат зээл	10	875,000.0	-
Өр төлбөрийн нийт дүн		13,931,623.7	14,031,977.9
Өмч / хувийн /	11	10,131,755.8	10,131,755.8
Нэмж төлөгдсөн капитал	13	56,213.1	56,213.1
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14	11,866,696.6	11,866,696.6
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)			
Тайлангийн үеийн	12	(4,314,224.5)	(4,986,104.5)
Өмчийн дүн		17,740,441.0	17,068,561.0
Нийт өр төлбөр, өмчийн дүн		31,672,064.7	31,100,538.9

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

	Лавлагаа	(мянган төгрөгөөр) 2016
Борлуулалтын орлого		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
Нийт ашиг алдагдлын дүн		
Үйл ажиллагааны зардал	15	634,255.0
Бусад зардал	16	37,631.7
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)		671,886.7
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	17	6.7
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)		(671,880.0)
Орлогын албан татвар зардал		-
Цэвэр ашиг (алдагдал)		(671,880.0)

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(мянган төгрөгөөр)

	Хувьцаат капитал	Нэмж Төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдс ан ашиг	Нийт дүн
2015 оны 12 сарын 31	10,131,755.8	56,213.1	11,866,696.6	(4,314,224.5)	17,740,441.0
Гаргасан хувьцаат капитал					
Залруулсан үлдэгдэл	10,131,755.8	56,213.1	11,866,696.6	(4,314,224.5)	17,740,441.0
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/				(671,880.0)	(671,880.0)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2016 оны 12 сарын 31	10,131,755.8	56,213.1	11,866,696.6	(4,986,104.5)	17,068,561.0

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(мянган төгрөгөөр)

2016

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	5,010.4
Даатгалын нөхөн олговороос хүлээн авсан мөнгө	
Бусад мөнгөн орлого	5,010.4
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	43,548.1
Ажиллагчдад олгосон мөнгө	19,995.4
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	3,000.0
Түүхий, эд материал худалдан авахад төлсөн мөнгө	3,686.4
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	
Түдш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	
Төлсөн хүү	
Татварын байгууллагад төлсөн	176.4
Даатгалын төлбөрт төлсөн	91.8
Бусад	16,598.1
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(38,537.7)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн	598,458.2
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	598,458.2
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
Мөнгөн зарлагын дүн	560,000.0
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	560,000.0
Төлсөн ногдол ашиг	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	38,458.2
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(79.5)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,339.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,260.2

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.



“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

“ХӨХ ГАН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 3 сарын 17-ны өдөр

№Т/3А

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.2, 61.1.5, 60.2-д заалтууд, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийг 244 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ХӨХ ГАН” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 13 цаг 30 мунитаас “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хурлын зааланд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
 - “Хөх ган” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай
 - Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалингийн зардал, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлын төсвийг батлах тухай
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2017 оны 3 дугаар сарын 21-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонинд, радио болон телевизийн аль нэгээр мэдээлсүгэй. Хурлын зар мэдээг анхны мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа өдөр тутмын нэг сонинд, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгнээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комиссет даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигч нь энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд ХУД, 15-р хороо “Бэрэн цамхаг байрны 15 давхарт “Хөх ган” ХК дээр ирж танилцаж болохыг дурьдсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар материал, 1 дүгээр хавсралтанд заасан баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөр тогтсугай.



7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг, хүлээн авах сүүлчийн өдрийг 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 13 цаг 30 минут байхаар тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Ц.Батболд-ыг, хурал зохион байгуулах комиссын даргаар Ц.Батболд-ыг, хурал зохион байгуулах комиссын гишүүнээр Н.Цэцэгдэмбэрэл нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Б.Амарбаясгалан -г, гишүүдээр Д.Шүрэнцэцэг-ийг тус тус томилсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/Б. Мөнхтөр/



“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1	Хурлын ирцийг бүртгэх	13:30 – 13:40
2	Хурлын ирцийг мэдээлэх	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллыг дагуу танилцуулах, санал авах	40 минут
5	Хурлын завсарлага	15 минут
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
8	Хурлыг хаах /Хурлын дарга/	5 минут

“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. “Хөх ган”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар
2. Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичиг.Үүнд:
 1. “Хөх ган”ХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
 2. Аудитын дүгнэлт
 3. Саналын хуудас
 4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоол шийдвэрийн төсөл
 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал
 6. 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
 7. “Хөх ган”ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Т/02 тоот “Ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн тогтоол”-ын хуулбар

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 9⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд ХУД, 15-р хороо, Бэрэн цамхаг байр, 15 давхарт хурал зохион байгуулах комисстой холбогдон танилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын огноо: 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

Хурал хуралдах цаг: 13:30 цагт

Хурал хуралдах газар: ”Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хурлын зааланд

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



“ХӨХ ГАН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

“Хөх ган” ХК-ийн 2016 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгогдон, Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд ТУЗ тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

Компанийн ТУЗ дараах бүрэлдэхүүнтэйгээр үйл ажилагаа явууллаа.

ТУЗ-ын дарга: Б.Мөнхтөр

ТУЗ-ын гишүүд: Ц.Батбаяр, Ц.Батболд, Б.Лхагвадорж, Д.Дагвадорж, Б.Мянганбаяр, Х.Батхишиг, Д.Чинбат, Д.Энхбат

Үйл ажиллагааны тухай

Тус компани нь дэлхийн зах зээлд төмрийн үнэ эрс унаснаас шалтгаалан төмрийн хүдрийн экспорт буурсан, улс орны эдийн засгийн хүндрэл, валютын ханшны өсөлт болон тус үйлдвэрийн үндсэн түүхий эдийг бэлтгэгч Архангай аймаг дах төмрийн хүдрийн уурхай, баяжмалын үйлдвэр удаан хугацаагаар зогссон зэрэг шалтгааны улмаас 2015 оны 2 –р улирлаас 2016 он бүтэн сул зогсолт хийгээд байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт

“Хөх Ган” ХК Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81,4 дүгээр зүйлийн дагуу үйл ажилагаагаа явуулсан бөгөөд “ХӨХ ГАН” ХК –ний санхүүгийн тайланд 2016 оны 12 дугаар сарын 31 байдлаар аудит хийж дүгнэлт гаргалаа.

“ХӨХ ГАН” ХК нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан ,санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу бэлтэгдсэн байна .

“ХӨХ ГАН” ХК нь Ай Жэй Эй Эйч –Аудитын газраар 3- жил санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэжээ.

2016 оны байдлаар их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ ,хэлцэл хийгдээгүй гэж үзэв.



“Хөх Ган “ХК -ий НББ –ийн бодлогын баримт бичгийг боловсруулж ,санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл, тайлан журналыг тогтмол хөтөлж , тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллах нь зүйтэй байна.

Мөнгө ба хөрөнгө оруулалтын дансны дотор зээл нөхөх албан ёсны ба албан ёсны бус сан байхгүй байна .

Иймд цаашид нөөц сан бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Аудитын хорооны дарга : С.Алтанцэцэг/

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: Б.Мөнхтөр



“ХӨХ ГАН” ХК-ИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

"Хөх ган ХК нь 2007 онд төсөл хэрэгжүүлж эхлээд өнөөдрийг хүртэл маш олон зүйлийг хийж бүтээгээд байна. Өнгөрөгч оны хувьд бид ширэмийн болон гангийн үйлдвэрлэлд хэрэглэгдэх гол түүхий эдүүдээс ганцыг үйлдвэрлэдэг байснаа өөрчлөн Монгол инженерүүдийнхээ тусламжтайгаар гурван төрлийн (шууд ангижруулсан төмөр, кокс, агломерат) бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой болсон нь бидэнд маш том амжилт юм. Тиймээс бид энэ амжилтаа баталгаажуулахын тулд энэ ондоо шинэ зүйл хийхээс илүүтэй дотоод руугаа хандсан ажиллуудыг илүүтэй хийх төлөвлөгөөтэй байна.

“Чанартай, Бүтээмжтэй, Амжилттай, Ашигтай” гэсэн уриатайгаар 2017 оныг ажиллана.

Хийх ажиллуудын хүрээнд доорх ажлыг төлөвлөв :

- ❖ Санхүү болон өртөг
- ❖ Үйлдвэрлэлтийн жигд ажиллагаа
- ❖ Хүний нөөцийн бодлого
- ❖ Чанар хангасан үйлдвэрлэлт хийх

Үүнд:

- Сүүлийн хэдэн жилүүдэд дэлхийн гангийн зах зээл уналттай байсан ба Монголд төмөрлөгийн бүтээгдэхүүний үнэ ханш уналттай байлаа. Энэ оны эхний улирлаас эхлэн гангийн зах зээл нь харьцангуй өсөлттэй байгаа хэдий ч бид үйл ажиллагаа эхлүүлэх хугацаагаа энэ оны 8 сараас гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Энэ хооронд бид урьдчилан шаардлагатай санхүүжилтийн хэмжээ болон бусад тооцооллуудыг гарган нарийн тооцоотойгоор ажиллахаар бэлтгэж байна.
- Өнгөрөгч онуудад бид шинэ технологи шинэ үйлдвэр гэдэг утгаараа маш олон туршилтуудыг явуулж жигд ажиллагаагаас илүүтэйгээр чанартай бүтээгдэхүүнийг илүүд тавьж байсан бол энэ жил бидний хувьд бүх талыг барьж жигд ажиллах гэсэн төлөвлөгөөтэй байгаа.
 - Түүхий эдийн нөөц бүрдүүлэх
 - Автоматжуулах
 - Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал болон сэлбэгийн нөөц хийх
- Ажлын байрыг автоматжуулж ажилчдын хийх ажлыг хөнгөвчлөх, нөхцлийг сайжруулах, хийснээрээ цалинждаг цалингын уян хатан системийг хэрэгжүүлэх, ажилчидыг мэргэшүүлэх сургалтууд зохион байгуулна.
- Бидний бүтээгдэхүүнийг худалдан авах үйлдвэр нээгдсэн явдал нь маш сайн зүйл боловч эсрэгээрээ чанартай болон хугацаандаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх зайлшгүй шаардлага гарч байгаа учир захиалсан хугацаанд чанартай бүтээгдэхүүнээр хангах



Үйлдвэрийн хүчин чадал 3 нэр төрлийн бүтээгдэхүүн

	DRI /тонн/	Агломерат /тонн/	Кокс /тонн/
1-р шугам	52	100	63
2-р шугам	86	115	85
Нийт өдрийн	138	215	148
Нийт 30 хоногт	2580	3450	2550
Нийт жилд	30960	41400	30600

2017 онд үйлдвэрлэх DRI хэмжээ хоног болон сараар

Үйлдвэрлэх хэмжээ	ШАТ (DRI) тонн	
	Хоног	Сар
Бага	52	1560 тн
Их	86	2580 тн

2017 онд үйлдвэрлэх DRI өртөг

DRI 1 сарын үйлдвэрлэлтийн хэмжээ		2580
Үйлдвэрлэлтийн 1 тн тутамд өртөг		
Шууд зардал	1 тн өртөг	Хувь хэмжээ
Нийт шууд зардал	345.7	81.3%
Нийт шууд бус зардал	79.5	19%
DRI өртөг	425.3	100%
НӨАТ –тэй борлуулах үнэ	467.8	

2017 оны борлуулалт урьчилсан төлөвлөгөө (3 нэр төрлийн бүтээгдэхүүн)

Бүтээгдэхүүн	1 сард үйлдвэрлэх тонн	5 сар үйлдвэрлэх тн	Борлуулах нэгж үнэ/тн	Борлуулалт /сая.төг/	Өртөг /сая.төг/	ТТӨАшиг /сая.төг/
Агломерат	3450	17250	305.8	5,275,050	4,795,500	479,550
DRI	2580	12900	467.8	6,034,620	5,486,370	548,250
Кокс	2550	12750	333.2	4,248,300	3,358,350	889,950

**“Хөх ган” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, нарийн бичгийн даргын цалингийн зардал,
хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлын төсөв****Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн зардал
1	МХБ-ийн бүртгэлийн хураамж	төгрөг	1,500,000
2	Хурлын материал бэлтгэх зардал	төгрөг	657,000
3	Бусад	төгрөг	300,000
	Нийт		2,457,000

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсөв

№	Зардлын нэр	Гишүүд	Сарын зардал	Жилийн зардал	Нийт (төгрөг)
1	ТУЗ-ийн даргын цалин	1	150,000	1,800,000	1,800,000
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин	8	120,000	960,000	11,520,000
3	ТУЗ-ийн нарийн бичиг	1	300,000	3,600,000	3,600,000
4	Хурлын зардал	9	10,000	120,000	1,080,000
	Нийт		280,000	3,360,000	18,000,000



НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР

ХӨХ ГАН



ХНУХН ГАН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 06 өдөр

Дугаар Т/02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хувиарлах эсэх тухай

"Хөх ган" ХК нь "Компанийн тухай хууль"-ийн 46.1, 46.2, 46.5, 46.6 заалтууд, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Хөх ган" ХК нь 2016 онд алдагдалтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүй байхаар тогтсугай.
2. Ногдол ашиг тараахгүй байх үндэслэл, шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигч нарт танилцуулсугай.
3. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигч нарт танилцуулсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга.....





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД:



*Бэрэнбал
МӨНХТӨР*

Иргэний харьяалал: Монгол

Төрсөн он: 1966

Боловсрол: Дээд

Мэргэжил: Цөмийн физикч

Ажлын туршлага:

- Физик техникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан /1990-1991/
- Радио телевиз- программист /1991-1992/
- “Бэрэн” ХЭАА-ийн захирал /1992-1997/
- “Атар-Өргөө” ХК-ийн захирал /1997-1998/
- “Бэрэн групп” ХХК-д Ерөнхий захирал, /1998 оноос одоо хүртэл/



*Цэдэнсодном
БАТБАЯР*

Иргэний харьяалал: Монгол

Төрсөн он: 1977

Боловсрол: Дээд

Мэргэжил: Үйлдвэрлэл, автоматжуулалтын инженер

Ажлын туршлага:

- “Бэрэн констракшн” ХХК-ийн ерөнхий инженер /2002-2005/
- “Бэрэн групп” ХХК-ийн ерөнхий менежер /2005-2010/
- “Бэрэн групп” ХХК-ийн гүйцэтгэх захирал /2010 оноос хойш/



*Цэдэнсодном
БАТБОЛД*

Иргэний харьяалал: Монгол

Төрсөн он: 1979

Боловсрол: Дээд

Мэргэжил: IT инженер

Ажлын туршлага:

- “Хөх ган” ХК-д гүйцэтгэх захирал, 13 жил ажилласан туршлагатай



*Батсүх
МЯНГАНБАЯР*

Иргэний харьяалал Монгол

Төрсөн он 1987

Боловсрол Дээд,

Мэргэжил: Бизнесийн менежмент

Ажлын туршлага:

- “СиБиЭм” ХХК Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн



*Бүрэнмэнд
ЛХАГВАДОРЖ*

Иргэний харьяалал: Монгол
Төрсөн он: 1976
Боловсрол: Дээд
Мэргэжил: Нефтийн инженер
Ажлын туршлага:
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн тэргүүн дэд захирал /1997 оноос одоо хүртэл/



*Данзан
ДАЯНБИЛГҮҮН*

Иргэний харьяалал: Монгол
Төрсөн он: 1976
Боловсрол: Дээд
Мэргэжил: Бизнесийн удирдлага
Ажлын туршлага:
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн гүйцэтгэх захирал /1997 оноос одоо хүртэл/



*Nick Gregory
Cousyn*

Иргэний харьяалал: АНУ
Төрсөн он: 1969
Боловсрол: Дээд
Мэргэжил: Эдийн засагч
Ажлын туршлага:
- Deutsche Bank- Институционал Борлуулалт, Арилжаа /2000-2002/
- Веллс Фарго Институционал Брокер-бондын арилжаа /2002-2004/
- Натексис Блэйхродер- Институционал Борлуулалт /2004-2006/
- ЭфТиЭн Мидвест Секюритис-ахлах дэд ерөнхийлөгч /2006-2009/
- СиЭрТи Капитал Групп – гүйцэтгэх захирал /2009-2012/
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал /2012 оноос одоо хүртэл/



*Дашзэвэ
ДАГВАДОРЖ*

Иргэний харьяалал: Монгол
Төрсөн он: 1957
Боловсрол: Дээд
Мэргэжил: Барилгын инженер
Ажлын туршлага:
- Сантехникийн үйлдвэрт мастераас орлогч дарга /1984-1987/
- “Ган хийц” үйлдвэрт орлогч дарга /1989-1999/
- “Өгөөж” ХХК-ийн ерөнхий захирал /1999-2005/
- “Дилькес” ХХК-ийн ерөнхий захирал /2005-оноос одоо хүртэл



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД:



*Даширэнчин
ЭНХБАТ*

Иргэний харьяалал: Монгол
Төрсөн он: 1975
Боловсрол: Дээд
Мэргэжил: Уулын цахилгааны инженер
Ажлын туршлага:
- “Өнөд дэвжих транс” ХХК захирал



*Дашипунцаг
ЧИНБАТ*

Иргэний харьяалал: Монгол
Төрсөн он: 1979
Боловсрол: Дээд
Мэргэжил: Механик инженер, менежер
Ажлын туршлага:
- “Вагнер Ази” ХХК-д худалдааны төлөөлөгч



*Халтар
БАТХИШИГ*

Иргэний харьяалал: Монгол
Төрсөн он: 1974
Боловсрол: Дээд
Мэргэжил: нефтийн инженер, эрх зүйч
Ажлын туршлага: “Нефть ойл” ХХК захирал



“Хөх ган” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 3. сарын 17 өдрийн Т/ЗА. тоот тогтоолын Хавсралт № 2

“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистерийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

“ХӨХ ГАН” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4 дүгээр сарын 28 -ны өдрийн 13 цаг 30 минутаас “БиДиСЕК ҮЦК”ХК-ийн хурлын зааланд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай			
2.	“Хөх ган” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай			
3.	Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалингийн зардал, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлын төсвийг батлах тухай			

(Та саналыг хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдэгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

2017 оны сар.....өдөр

**“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистрийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо Кумулятив саналын тоо.....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани /

Брокерийн овог нэр

“ХӨХ ГАН” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2017** оны **4** дүгээр сарын **28**-ны өдрийн **13 цаг 30** минутаас “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хурлын зааланд болно.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
	Ердийн гишүүд:	
1	Б.Мөнхтөр	
2	Ц.Батбаяр	
3	Ц.Батболд	
4	Б.Мянганбаяр	
5	Б.Лхагвадорж	
6	Д.Даянбилгүүн	
7	Nick Gregory Cousyn	
8	Д.Дагвадорж	
	Хараат бус гишүүд:	
1	Д.Энхбат	
2	Д.Чинбат	
3	Х.Батхишиг	

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

Брокер Гарын үсэг

/ тэмдэг /

2017 оны сар..... өдөр

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. **Жишээ нь:** та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
3. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 91030035, 99052845 утсаар лавлаж болно.
5. Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан



төсөл

“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№1

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, “Хөх ган” Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Хөх ган” Хувьцаат компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга



Төсөл

“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№2

Улаанбаатар хот

“Хөх ган” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

“Хөх ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Хөх ган” хувьцаат компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.

Хурлын дарга



“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№3

Улаанбаатар хот

**Компанийн ТУЗ гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ХЭХ-ын зардлыг
төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 заалт, “Хөх ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Хөх ган” хувьцаат компанийн 2017 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг 20,457,000 төгрөгөөр баталсугай.

Хурлын дарга



төсөл

“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№4

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Хөх ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Хөх ган” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр

1.
2.
3.
4.
5.
6.

Хараат бус гишүүдээр

7.
8.
9. нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

Хурлын дарга